



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 1105

Хараат

Цэвэр орчин, ногоон байгууламжийг
нэмэгдүүлэх жил болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь заалт, сумын Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын өнгө үзэмж, иргэдийн ажиллаж, амьдрах орчныг сайжруулах, иргэд, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын оролцоотой цэвэр, тохилго орчныг бүрдүүлж, “8 түмэн мод”, “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 2022 оныг “Цэвэр орчин, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил” болгон зарласугай.

2. “Цэвэр орчин, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил”-ийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Жилийн ажлын төлөвлөгөөг батлуулж, удирдлага зохион байгуулалтаар ханган, үе шаттайгаар аян болон бусад төрлийн арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцон иргэд олон нийтэд мэдээлж ажиллахыг сумын Засаг даргын орлогч, ажлын хэсгийн ахлагч (Н.Батгэрэл)-д үүрэг болгосугай.

4. Цэвэр орчин, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд иргэд, олон нийтийг уриалж ажиллахыг төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын удирдлагууд, багийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Зорилтот жилийн хүрээнд хийгдэх арга хэмжээнд шаардагдах зардлыг аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хандив, дэмжлэг, төсөл хөтөлбөрөөр санхүүжүүлж ажиллахыг байгууллагын удирдлагуудад зөвшөөрсүгэй.

6. Идэвх санаачлагатай оролцсон аж ахуйн нэгж байгууллага, айл өрх, иргэдийг шагнаж урамшуулахад шаардагдах хөрөнгийг тухай бүр Засаг даргын зөвлөлийн хурлаар

хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Солонго),
санхүүгийн албаны дарга (Б.Цэндмаа) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БУДЖАВ

Сумын Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 1105 дугаар захирамжийн хавсралт

**“ЦЭВЭР ОРЧИН, НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЖИЛ”-ИЙН
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: -Н.Батгэрэл (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: -А.Цогзолбоо (Байгаль орчны мэргэжилтэн)

Гишүүд: -З.Солонго (Засаг даргын Тамгын газрын дарга)

-Б.Алдармаа (Соёлын төвийн дарга)

-Д.Октябрь (Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

-Д.Сарантуяа (Цэцэрлэгийн эрхлэгч)

-Б.Баярбаатар (Эрүүл мэндийн төвийн дарга)

-Г.Жаргалмаа (Хараат 1 дүгээр багийн Засаг дарга)

-И.Эрдэнэбат (Дэлгэрэх зам 2 дугаар багийн Засаг дарга)

-Ц.Ундрахбаяр (Жаргалант 3 дугаар багийн Засаг дарга)

-Б.Балжинням (Замын улаан 4 дүгээр багийн Засаг дарга)

-Б.Цэндмаа (ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга)

-З.Алтанхуяг (ИТХ-ын төлөөлөгч, иргэний төлөөлөл)